



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

"Талын салхи 2026" олон улсын мото наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/804 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор "Талын салхи-2026" олон улсын мото наадмыг 2026 оны 06 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд "Говь ресорт" спорт цогцолборт зохион байгуулсугай.

2.Арга хэмжээ зохион байгуулах төсвийг хавсралтаар баталсугай.

3."Талын салхи-2026" олон улсын мото наадмыг зохион байгуулахад шаардагдах төсвийг холбогдох зардлаас хууль, журмын дагуу гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4.Арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

